



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 11305

Улаанбаатар хот

Гадаадын сургалтын байгууллагад  
суралцах суралцагчдын хяналтын тоо  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэхь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай" 115 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэл", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх" журмын 1.9 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр 2024 онд гадаадын сургалтын байгууллагад тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр магистрийн үндсэн хөтөлбөрт суралцагчдад 30, докторын үндсэн хөтөлбөрт суралцагчдад 20, нийт тэтгэлэг олгох хяналтын тоог 50 байхаар баталсугай.

2. Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 2024 онд сургалтын зээл олгох хяналтын тоог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Times Higher Education World University Rankings", эсхүл "Academic Ranking of World Universities" байгууллагын сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 50-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан суралцагчдад нийт зээл олгох хяналтын тоог 70 байхаар баталсугай.

3. Батлагдсан хяналтыг тоог баримтлан батлагдсан төсөвтөө багтаан Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг, сургалтын зээл олгох, цаашид гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын судалгаа тайланг тогтолгаргаж, тухай бүр яаманд ирүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сан (Б.Амарсанаа)-д даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Дээд боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газар (Х.Тамир), Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар (Ш.Нарантуяа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т тус тус даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

14241 1034